#### БҮТЭЭЛИЙН ХУУЛБАРЛАЛТ ШАЛГАХ "БҮТЭЭЛИЙН ХУЛГАЙГААС СЭРГИЙЛЭХ СИСТЕМ" АШИГЛАХ ЗААВАР

## 1. Танилцуулга

"Бүтээлийн хулгайгаас сэргийлэх систем" нь тухайн баримтыг систем дэх бүтээлийн сантай харьцуулан шалгаж бүтээлийн хуулбарлалт хийгдсэн эсэхийг таамаглан харуулна. Системд <u>http://pds.num.edu.mn</u> хаягаар хандаж ашиглана.

Анхаарах: Систем нь зөвхөн бичвэрийг шалгана. Эшлэл, зураг, график, диаграмм таниулах хөгжүүлэлт хараахан хийгдээгүй байгаа болно.

## 2. Ашиглах заавар

Энэ хэсэгт системд хэрэглэгчээр хэрхэн нэвтэрч баримтыг бусад эх сурвалжаас хуулбарлалт хийгдсэн байх магадлалыг шалгах тухай мөн бүтээлийн санд баримтуудыг хэрхэн оруулахыг зааж үзүүлэв.

### 2.1. Хэрэглэгчээр нэвтрэх

Баримтыг шалгах, бүтээлийн санд баримтыг индексэлж оруулахдаа хэрэглэгчээр нэвтэрсэн байх шаардлагатай. Үүний тулд МУИС-ийн багш, ажилчдын СиСи эрхийг ашиглана. Системд анх хандахад дараах зурагт үзүүлсэн нүүр хуудас харагдана.

МУИС-Бүтээлийн хулгайг х	Amarsanaa		×
← → C ft ] pds.num.edu.mn	ዋ 📇 🗹	0	≡
Бүтээлийн хулгайгаас сэргийлэх систем			
Системийг ашиглахын тулд та SISi эрхээрээ нэвтрэх шаардлагатай.		1	
нэвтрэх		1	
	() (ME) (ME) (ME)	1 1 1	
2015 © МУИС, Машин оюуны лаборатори			

#### Зураг 1. БХС системийн нүүр хуудас

Нэвтрэх товчийг дарахад СиСи хэрэглэгчийн нэвтрэх хуудас руу шилжинэ. Энд СиСи эрхээрээ нэвтэрч ороход автоматаар системд нэвтэрнэ.

**!!!** Нэвтрэх явцад **Зураг 2**-т үзүүлсэн аюулгүй байдлыг илтгэх цонх гарч ирсэн тохиолдолд зүүнд доод талд байрлах "*Send anyway*" товчыг дарж үндсэн цонх руу шилжинэ.



Зураг 2. Аюулгүй байдлыг илтгэх цонх

## 2.2. Баримтыг шалгах

Системд нэвтэрч орсны дараа баримтыг (document file) шалгах үндсэн хуудас (Зураг 3) харагдах бөгөөд шалгах файлаа системд хуулж өгнө.

Дараах файлын төрлөөс сонгон системд шалгуулна уу.

- Майкрософт оффис программын файлууд: Жишээ нь \*.doc, \*.docx, \*.xlsx, \*.pptx гэх мэт.
- ▶ Portable Document Format (PDF): PDF файл

Файлыг **Файл...** талбарын ард байрлах цаасны хавчаар зураг дээр дарж эсвэл өөрийн компьютерийн файл хөтчөөс (жишээ нь, Windows Explorer) чирч веб хөтчид харагдах энэ хуудасны тасархай хүрээгээр хязгаарласан талбайд байрлуулснаар хийж гүйцэтгэнэ.

Ингэхдээ доод хэсэгт байрлах "Бүтээлийн санд хуулах" гэсэн дөрвөлжин нүдийг идэвхжүүлэхгүй. Энэ нь тухайн баримтыг системийн нэгдсэн санд хуулдаг тохиргоо тул буцааж устгах боломжгүй болно.



Зураг 3. Баримтыг шалгах хуудас

Үүний дараа **Зураг 4-т** үзүүлсэн цонх гарч ирнэ. Энд таны хуулж буй файлыг бүрэн хуулж дууссан бол ШАЛГАХ товчлуур гарч ирнэ. Хэрэв та буруу файл хуулсан бол *өөр файл сонгох* холбоос дээр дарж өөр файл дахин хуулах боломжтой.

МУИС-Бүтээлийн хулгайг х	Amarsanaa	- C	ı ×
🗲 🔿 😋 👬 🗋 pds.num.edu.mn/plagia.html?sisiID=10011000855&fname=Амарсанаа%2B&Iname=Ганболд 😪 🥵	M 🔜 🗹	0 📕	
🛞 Бүтээлийн хулгайгаас сэргийлэх систем 💲	Ганболд Амарсана	ia 🕞	
a suspicious document.odt 61.95 KB		1	
Файлыг хуулж дууслаа. Бүтээлийн хулгайг шалгах уу? Эсвэл өөр файл сонгох ШАЛГАХ			
I Records address	ani ani ani ani	1	
2015 © МУИС, Машин оюуны лаборатори			

Зураг 4. Файлыг системд хуулсны дараа шалгах хэсэг

Хэрэв файлыг шалгах бол ШАЛГАХ товчлуурыг дарж бүтээлийн хулгайн таамаглалыг харна. Үүний дараа **Зураг 5-д** үзүүлсэн цонх гарч ирнэ. Энд баримтын хэдэн хувь нь бүтээлийн санд байгаа файлуудад хуулбарлагдаж орсныг харуулах ба хуулсан байж болзошгүй бичвэрийг хуудасны зүүн талд харуулна.



Зураг 5. Баримтын бүтээлийн хулгайн таамгийг харуулах

Хуулсан байж болзошгүй бичвэрийн урд шар өнгөөр тэмдэглэж ялган харуулдаг. Хэрэв хуулсан байж болох бичвэр дээр дарвал тухайн бичвэр хэдэн хувь хуулагдсаныг харуулна. Жишээ нь **Зураг 6-д** тухайн бичвэр 96% адилхан байгааг харуулна. Үнэн хэрэгтээ зурагт үзүүлсэн жишээн дээрх бичвэрүүд хоорондоо яг ижил боловч Монгол хэлний нь гэх үг өгүүлбэрийн утгад нөлөөлдөггүй учир таамгийн бодолтоос хасаж тооцсон болно.



Зураг 6. Хуулсан байж болзошгүй бичвэр

Хэрэв нэг бичвэр хэд хэдэн баримтад олдвол тус тусад нь хуулсан байж болох хувийг бодож харуулна.

Мөн *Бүтээлийн сангаас* хэсэгт хуулсан байж болзошгүй баримтуудыг харуулах ба файлын нэрийн өмнө нь тухайн баримтаас хэчнээн хувийг хуулсан байж болохыг хувиар харуулдаг. Энэ файлын нэр дээр дарж тухайн файлаас ямар ямар хэсгийг хуулсныг харах боломжтой (**Зураг 7**).



# Зураг 7. Хуулсан байж болох файлын бүх бичвэрүүд